

## ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

**БАЛАР ЭРТНИЙ ХЯТАДЫН ТҮҮХИЙН ЗАРИМ АСУУДАЛ  
(Ангит нийгэм үүсэх урьтал нөхцөл)****Н. Ишжамц**

ШУА-ийн сурвалжлагч гишүүн

Нийт Хятадын түүх, түүний дотор балар эртний Хятадын түүхийн асуудлыг олон орны эрдэмтэд янз бүрийн чиглэлээр судалсаар ирсэн билээ. Хүй нэгдлийн байгууллын үеийн Хятад орон, түүний туулж өнгөрүүлсэн түүхийг марксист түүхчид онол—аргазүйн хамгийн үнэн зөв байр сууринаас судлан боловсруулж, олон чухал асуудлыг тодруулаад байна. Хөрөнгөтний түүх судлалд археологийн баримт, түүхэн зарим үйл явдал, эртний хятад хэлний асуудлыг судалж тодруулах талаар нилээд зүйл хийгдсэн боловч онол—аргазүйн хувьд ихээхэн доголдолтой явж ирсний дээр үзэл суртал, улс төрийн хувьд харш, харгис зүйл ч багагүй гарчээ. Үүний хажуугаар хятадын маоист үзэлтэнгүүд сүүлийн 20 гаруй жилийн турш эх орныхоо эрт, эдүгээгийн түүхийг элдвээр завхруулж, хөрөнгөтний түүх судлалын харгис жигүүртэй дуу хоолойгоо нийлүүлж ирэв. Гэвч хятадын түүхийн бүх баримт, дэлхий нийтийн хятад судлалын гол ололт амжилтууд нь балар эртний хятадын түүхийн тухай марксист судалгааны үнэн мөнийг нотолж байна.

Түүхийн шинжлэх ухаан, хятадын судлалд нэгэнт нотлогдсон тогтоогдсон ёсоор Хятад орны амьдрал хөгжил нь бусад улс орныхтой нэгэн адил өөрийн өвөрмөц онцлогтой байсан боловч балар эртний үед ч гэсэн хүний нийгмийн хөгжлийн нийтлэг зүй тогтол, жам ёсыг дагаж байжээ.<sup>1</sup> Хүний гарал үүсэл Хятадад оршин амьдарч байсан анхны хүмүүс буюу тэдний өвөг дээдсийн тухай эртний хятадын түүх, аман зохиолын уламжлал болоод гүн ухааны зохиолд сонин мэдээ тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Тухайлбал эртний хятадын философич Хань Фэйцзын зохиолд хамгийн балар эртний анхны хүмүүс «араатан амьтнаас айн сэргийлж, ойн модон дээр үүрлэн амьдардаг байв» гэсэн зүйл бий. 5—6 зуун мянган жилийн өмнөх үеэс эхлэн<sup>2</sup> Хятад оронд оршин амьдрах болсон хуучин чулуун зэвсгийн доорд үеийн мичин хүмүүс нь<sup>3</sup> хөдөлмөрийн зарим багаж зэвсэг үйлдэж чаддаг болоод байсан боловч овог аймаг, гэр бүл болж ялгараагүй, анхны хүн сүргийн маягаар амьдарч байжээ. Гагцхүү МЭӨ 100—40 орчим мянган жилийн урьд амьдарч байсан хуучин чулуун зэвсгийн дунд үеийн

<sup>1</sup>Хятадын нэвтэрхий түүхийн тойм, дээд дэвтэр, Бээжин, 1949, Удиртгалын 1-р тал (хятадаар)

<sup>2</sup>Бай Шоули, Хятадын ерөнхий түүхийн хураангуй тойм, Шанхай 1980, (хятадаар) 14-р талд мичин хүний яс Хятадаас сүүлийн үед олдсон нь 1 сая 700 мянган жилийн өмнөх үед хамаарах тухай дурджээ. Жинхэнэ мичин хүний тоонд «лань—тянь», «синантроп» зэрэг хятадын мичин хүн маргаангүй ордог юм.

<sup>3</sup>Мөн тэнд, 26-р тал

заримдаг мичин хүмүүс үрэлтээр гал гарган хэрэглэж чаддаг болсон байжээ. Дээр дурдсан Хань Фэйцзын зохиолд Хятадад анх Сүй Жэнь гэдэг хүн «үрэлтээр гал гаргаж, түүн дээрээ мах шарах» арга олж, бусаддаа сургасан, чухам тэр цагаас эхлэн «гал гарган хэрэглэгчид» бий болсон гэсэн түүхэн домог тэмдэглэгдэн үлдсэн байна. Заримдаа мичин хүмүүс эхийн эрхт ёсны овог төрлийн зохион байгуулалттай болсон байна.<sup>4</sup> МЭӨ 40—13 мянган жилийн өмнө хуучин чулуун зэвсгийн дээд үед сэтгэхүй оюун жигдэрсэн жинхэнэ хүний нийгэм бий болж, нийгмийн хөгжлийн зүй тогтлоор замнах болсон байна.

Хуучин чулуун зэвсгийн дээд үед хүмүүс зэрлэг нохойг анх гэрийн тэжээвэр амьтан болгож, араатан дайснаас сэргийлэх, ан гөрөө хийх зэрэгт ашиглах болсон нь тэдний чухал ололтын нэг байв. Монгол, Төвд, Туркстан, Манжуур, Сибирь зэрэг газар оронтой зэрэгцүүлж үзвэл тэр үеийн хятадад шар арьстаны өөр нэгэн салаа мөчрийн олон овог оршин амьдарч байсан<sup>5</sup> боловч ястан угсаатны ялгаа хараахан гараагүй байв. Харин тухайн үеийн хүмүүс тодорхой ялгарсан хэл, соёл, зан заншилтай болоод байсан байна. Тэд байгалийн үзэгдэл, ургамал, амьтан, уул усыг шүтэн биширч мөн сүнс, хойт насны тухай шашны зарим ойлголт гарган сүсэглэх болж байжээ.

Маоист түүхчид эртний хятадын соёлын түүхэн баримтыг хэт дөвийлгөж, чухам түүний ачаар хөрш зэргэлдээх орнууд соёлд орсон мэт үздэг. Гэтэл зэргэлдээх орнуудад биеэ даасан өвөрмөц соёл хөгжиж Хятадад бас нэвтрэн нөлөөлж байсан явдал судалгаагаас илэрсэн юм. Хуучин чулуун зэвсгийн дээд үед Монгол оронд чулууны харьцангуй өндөр соёл анх бий болж, Хятад зэрэг зарим оронд дэлгэрч байжээ. Зөвлөлтийн эрдэмтдийн шинжилгээний үр дүнгээс үзвэл: «Умард Азид ул мөр нь энд тэндгүй илэрсэн хуучин чулуун зэвсгийн дээд үеийн эртний өвөрмөц соёл нь Азийн аль нэгэн гүнд, тухайлбал ялангуяа Ар монголд анх үүсч бий болоод... дараа нь зүүн урагш Шар мөрний зүг, умар тийш Якут өөд баруун тийш Урал руу түүнчлэн мөн Эрчис мөрний эхэн урсгалд тус тус тархан дэлгэрсэн нь тун магадтай»<sup>7</sup> ажээ.

МЭӨ XIII мянганы үеэс МЭӨ VII мянган хүртлэх үеийн Хятадад дунд чулуун зэвсгийн үеийн хүмүүс оршин амьдарч байжээ. Тэд чулуу, ясаар сүх алх хийж хэрэглэдэг байсны дээр нум сум үйлдэх болоод байв. Эртний Хятадын «Ицзин» номын дотор хүмүүс «Мод махийлгаж, нум үйлдээд, сум хийдэг болсон» гэсэн мэдээ байдаг. Хэрэв урьд нь хүн зэрлэг үр жимс түүвэрлэн цуглуулах, ан гөрөө хийх зэргээр байгалийн бэлэн бүтээгдэхүүн бэлэнчлэн хэрэглэж байсан бол дунд чулууны үеэс эхлэн зарим ургамлыг тарьж, зарим амьтныг мал болгон хэрэглэж чадах болж байв. Олон овгоос аймгууд анх үүсэн бий болж мөн овгуудын хэл аялгаас аймгийн хэл бүрэлдэн тогтож байжээ. Чухам тэр үеэс л Шар мөрний дунд урсгалын хэсэгт ирээдүйн хятад аймгуудын хэл аялгууд үүсэн бүрэлдэх суурь тавигдаж байсан байж болох талтай юм.

МЭӨ VII мянганаас МЭӨ III мянганы үед Хятадад чулуун багаж зэвсгийн үйлдвэрлэл нэн хөгжиж, шинэ чулуун зэвсгийн үе зонхилж байв. Хүмүүс чулууг чулуугаар зүсэж, нүхэлж, билүүдэж, зүлгэж гөлийлгөн өнгөлж сурсан байв. Цахиур зэрэг бусад чулуунаас гадна

<sup>4</sup>Мөн тэнд. 31—32-р тал.

<sup>5</sup>Люй Гуаньтянь, Умардын угсаатны хүй нэгдлийн байгууллын судалгаа, Нинся. 1981 (хятадаар) 12—13-р тал.

<sup>7</sup>Всемирная история, т. 1, М., 1955. с. 81

нефрит хаш мэтийн эрдэнийн чулууг янз бүрээр засан хэрэглэж чадах болжээ. Ялангуяа шавар сав үйлдэж шатаан бэхжүүлж хэрэглэхдээ ихэд дадсан байв. Шавар савыг хээ угалз гаргаж будаж янзлан нилээд гоёмсог үйлддэг байв. Хятадаас олдсон хамгийн эртний тийм шавар савнууд нь хийц байдал, хээ угалз, өнгө будаг сэлтээрээ эртний Энэтхэг, Вавилон ба Египетийнхтэй төсөөтэй байдаг байна. Энэ нь Умард Африк, ойр дорнод ба Өмнөд Азийн соёл Хятад ба нийт Алс Дорнод, Төв Азид нэвтрэн нөлөөлж байсны гэрч баримт байж болно. Хятад ба эртний дорнодахины бусад орнууд өвөр хоорондоо аливаа хэмжээ хэлбэрээр соёлын харилцаатай оршин хөгжиж байсан нь мэдээж хэрэг Хятадын үндсэн нутаг дээрээс олдсон шинэ чулуун зэвсгийн үеийн соёлын хамгийн хөгжсөн нь МЭӨ IV— III мянганы үеийн Яньшаогийн соёл юм. Яньшаогийн соёл бол Шар мөрний дунд урсгал, Хэнань мужид төвлөрч, орчин тойронд нилээд дэлгэрч байжээ. Яньшаогийн шавар сав нь гадуураа улаан будагтай, ихэвчлэн эргүүлгэн хүрдэн дээр хийгдсэн байдаг байна.

Шинэ чулуун зэвсгийн үед хүмүүс тариа тарьж, мал маллаж амьдран байв. Тэр үеийн Хятадад нэгэнт гахай, хонь, ямаа, үхэр, адуу маллах болоод байсан боловч чүмүза хэмээх нэгэн зүйлийн шар будаа, цагаан будаа зэрэг тариа тарих ажил аж ахуйд зонхилж байв. Эртний хятад түүхэн домог ёсоор бол анх Шэнь Нүн гэдэг хүн «Мод зорж анжисны хушуу хийгээд мөн мод махийлгаж анжис үйлдэн» тариа тарих арга олсон бөгөөд Фуси гэдэг хүн амьтан тэжээж мал маллах арга олсон гэдэг байна. Энэ бүхэн домог боловч бас сонирхолтой зүйлийн нэг юм. Тухайн үеийн хүмүүс шар мөрөн гэдэг гол усан дээр далан барьж үерээс сэргийлэх, суваг шуудуу татаж тариан талбайг усжуулах болж байсны дээр сэлүүрт модон завь үйлдэж, мөрөн гол, нуур усанд явж чадах болсон байв.

Шинэ чулуун зэвсгийн үеийн хүмүүс нилээд олноороо нэг доор бөөгнөрч, орон сууц, тосгон суурин барьж оршин амьдардаг байжээ.

Хятадын шинэ чулуун зэвсгийн үеийн шавар сав зэрэг зүйлийг Синьцзяны, Ганьсугийн, Шаньсигийн, Хэнаний, Сюйюаний, Манжуурынх гэх зэргээр ялган салгаж болно. Тэхдээ тэдгээрийн дотроос Синьцзян, Ганьсу, Сюйюань, Манжуурынх нь Төв Хятадынхаас ихээхэн ялгаатай, харин өвөр хоорондоо тун төсөөтэй байна. Сюйюаний шавар сав нь нийтдээ Монголынхтой нэн төсөөтэй, учир нь Сюйюань, түүний хойд хэсэг нь чухамдаа Өвөр Монголын нутаг юм.

Шинэ чулуун зэвсгийн үед, ялангуяа яньшаогийн үед нэгэнт балар эртний Хятад аймаг овгууд тус тусын хэл аялгуудын хамт ялгаран гарч ирсэн байна. Тэдгээр аймгуудын газар тариалан, мал аж ахуйд ахиц гаргахын хамт эхийн эрхт овгийн хуучин ёс нь эцгийн эрхт овгийн харьцангуй шинэ ёсоор солигдож, эцгийн эрхт томоохон аймаг овгууд бий болсон байна.

Хүй нэгдлийн байгууллын үед хүмүүс тийнхүү овог аймгаар оршин, эрх тэгш, харьцангуй эрх чөлөө, эв нэгдэлтэй амьдарч байжээ. Тэр тухай Күнзийн «Лицзи» сударт тэмдэглэсэн зүйлээс үзвэл: «Их шударгын ёс зонхилж, тэнгэрийн доорхи зүйл бүхэн нийтийнх байх үед мэргэд чадвартныг сонгон дэвшүүлж, итгэл найдвар дээр тулгуурлан, энх тунх, эв найрамдалтай байж билээ. Хүмүүс эд хөрөнгөө байсан газартаа орхиод явахаас биш, өөрийн гэрт нуун дарахгүй байв. Хүчин чадлаа зөвхөн өөрийн хар амины ашиг тусад зориулахын оронд ерөөс огт гаргахгүй байх нь дээр гэж үзэж байв. Үүний улмаас хорон санаа төрөхгүй хулгай дээрэмгүй, үүд хаалга задгай байдаг байв»<sup>8</sup> гэсэн байна.

<sup>8</sup>История Китая с древнейших времен до наших дней, под редакцией Л. В. Симановской и М. Ф. Юрьева, 1974, 9-р тал

МЭӨ III мянганы дэд хагас, II мянганы эхэн үе бол Хятадад Луншаний соёлын үе, тухайлбал хятад аймаг, овгуудын дотор зэс боловсруулж сураад, зэс, чулуун зэвсгийг хослон хэрэглэж байсан үе, хэрэг дээрээ хүрэл зэвсгийн эхэн үе юм. МЭӨ II мянганы үед Хятадад хүрэл боловсруулах үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж, хөдөлмөрийн багаж, сав суулга, агнуурын ба байлдааны хурц хүрэл зэвсэг олноорыг үйлдэж хэрэглэх болсон байв. Луншаний соёлын эхэн үе буюу зэс—чулууны үед Хятадад үйлдвэрлэх хүчин, аж ахуй улам ахицыг олж, нийгмийн гишүүд зөвхөн өөрийнхөө амины хэрэгцээг хангахаас илүү нэмүү бүтээгдэхүүн үйлдвэрлэх болжээ. Гэвч тэрхүү нэмүү бүтээгдэхүүнийг гол төлөв овог, аймгийн ахлагч нар авч хэрэглэх болж, овог, аймгийн сурвалжит язгууртан нар бусдаас давуу хүч нөлөөтэй болж ялгаран байв. Тэдгээр аймаг, овгийн сурвалжит язгууртан нар өвөр хоорондоо янз бүрээр өрсөлдөн тэмцэлдэх болж, нэг овог аймаг нь нөгөөгийн эсрэг дайн байлдаан цөөнгүй хийх болж байв. Дайнд ялсан овог аймаг, тэдгээрийн тэргүүн, сурвалжлагч язгууртан нар нь эд хөрөнгө олзолж авахаас гадна ялагдсан овог, аймгийн хүмүүсийг боол болгон хэрэглэх болж байв. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэж, өөр овог аймгийг эзлэн боолчлох зорилгоор зарим аймаг, овгийн сурвалжит язгууртан нар нь түр зуурын ба урт удаан хугацааны холбоо байгуулж дайн тулалдаанд орох болж байв. Ингэж хятадад анхны аймгуудын холбоо байгуулагдаж, «цэргийн ардчилал» тогтож эхэлсэн байна.

МЭӨ III мянганы дэд хагасад Шар мөрний дунд урсгалд, одоогийн Хэнань, Шаньси, Шэньси болон Шаньдүн мужуудын нутагт Хуанди, Яньди, И гэх мэтийн үндсэн хятад угсааны аймгууд оршин амьдарч байжээ. Хятад аймгууд нэгдмэл нэргүй байсны дээр аймаг тус бүр нь газрын нэр, амьтны нэр, зонхилогчийн нэрээр нэрлэгдэж байжээ. Хуанди аймгийн зонхилогч нь мөн Хуанди гэдэг сурвалжит язгууртан байсан бөгөөд түүний үед Хуанди аймаг нь бусдаас илүү хөгжиж, хүчийг олоод Хятадын гол тулгуур аймаг болсон байна. Хуанди нь өөрийн аймаг болон баавгай, барс, ирвэс гэх зэрэг араатныг онголон шүтдэг зарим хятад аймгуудыг толгойлж, Яньди, И гэх мэтийн бусад хятад аймгуудыг нэгтгэн Хятадын анхны томоохон цэрэг—аймгийн холбоог байгуулж, түүгээрээ хойч үеийн түүхэнд ихэд нэр гарсан юм. Хуандийн үед Хятад аймгууд буудай буюу буудайн төрлийн тариа тарьж, гурил хийх боломжтой болсон байна. Мөн тэр үед завь, тэрэг, таван өнгийн будаг үйлдэж чадах болсныг Хуандийн нэртэй холбож ярьдаг байжээ. Тухайн үеийн хятадын эдийн засгийн хөгжлийн шинэ томоохон ололтын нэг нь хятадууд ялам мод тарьж, торгоны хүр хорхой үржүүлэн торго нэхэж чадах болсон явдал юм. Түүх, домгийн дотор Хятадад торгоны хорхой үржүүлэх аргыг Хуандийн гэргий анх сэдэж гаргасан гэх боловч үнэн хэрэг дээрээ торго нэхэх арга ажиллагаа нь нийт хятадын ард түмний ур чадвартай салшгүй холбоотой юм. Хятадын ард түмэн дэлхий дээр анх удаа торго нэхэх арга ухаан сийлж, хүн нийгмийн эдийн засаг, соёлын хөгжилд чухал хувь нэмэр оруулсан юм.

Маоист түүхчдийн бичсэн зарим зохиолд Хуанди ууган хятад аймгуудаас гадна Улаан ди, цагаан ди, умард ди гэх зэрэг хүннү монголчуудын дээд овог болох олон аймгуудыг байлдан эзэлж, тэр үеэс эхлэн тэд хятадуудтай ижилсэн уусаж, нэгдмэл хятад үндэстэн үүсэн бүрэлдэхийн эх суурийг тавьсан гэсэн зүйл байдаг.<sup>9</sup>

Гэтэл Хуанди нь Шар мөрнөөс хойших улаан ди, цагаан ди гэх зэрэг иран, түрэг угсааны зарим аймагтай байлдаж байсан байж болох

<sup>9</sup>Хятадын түүхийн тойм, ерөнхий редактор Го Можо. 1-р дэвтэр, Бээжин, 1976, 6—7-р тал

боловч тэднийг бүгдийг эзлэн уусгаж ижилсүүлж байгаагүй юм. Тэгэх тусмаа Хуандийн үед хятадууд Монгол нутагт нэвтэрч, хүннү, монгол, угсаатны дээд өвгүүдийг эзэлж, хятадад нэгтгэх чадал байгаагүй юм. Тийм учир хүннү, монголчууд зэрэг Төв Азийн эртний аймгууд угаасаа хятадын нэг хэсэг мөн гэсэн маоистуудын номлол огт үндэсгүй юм.

Хуандигаас хойших үед хятад аймгуудын холбооны зонхилгоор нилээд сурвалжтан удаа дараалан сонгогдож байсны дотроос хамгийн нэртэй нь Шао Хао, Чжунь Сюй, ялангуяа Яо Шүнь, Юй нар юм.<sup>10</sup> Хао Шао зүүн зүгийн харь И аймгуудыг байлдан эзэлж байжээ. Чжунь Сюй өмнө зүгийн мань угсааны Цзюли, Мяо аймгуудыг байлдан эзэлж газар усны онгон савдаг шүтэх шүтлэгийг нь хүчээр устган хятадын бөө мөргөлд тэднийг албадан оруулж байжээ. Тухайн үеэс эхлэн Хятадад «Ү» гэх зэрэг бөө удган нар олширч, бөө мөргөл нэг хэсэгтээ зонхилох байдалтай болж байв.

Аймгийн холбооны зонхилгогч нар үе залгамжилдаггүй, сурвалжит язгууртны зөвлөлөөс нэр дэвшигдэн сонгогддог байсан юм. Тэр үед сурвалжит язгууртны зөвлөл, аймаг овгийн гишүүдийн хурал их хүч нөлөөтэй байв. Гэвч аймаг овгийн гишүүдийн хурлын хүч нөлөө цаашдаа бага болж, гол төлөв овог, аймгийн ахлагч нар оролцдог сурвалжит язгууртны зөвлөл нилээд эрхтэй үлдсэн байна. Аймгуудын холбооны зонхилгогч нь дайн тулалдааны үед аймгуудын цэргийг оройлон удирддаг, энгийн цагт харьяа аймгуудын ял халдсан ахлагчдыг шийтгэдэг, газар нутгийг эргэж үздэг, тэнгэр тахих зан үйлийг толгойлж явуулдаг байжээ.

Түүхэн домог ёсоор бол Хуандигаас хойш таван үе өнгөрсний дараа Яо гэдэг сурвалжит язгууртан хятадын аймгуудын холбооны зонхилгогч болсон, 9 үеийн дараа Шүнь, 10 гаруй үеийн дараа Юй нар тус тус зонхилгогч болсон байна. Тэдний үед Хятадад гадуураа зузаан шавар хэрэм бүхий хот суурин газрууд бий болж байжээ. Яо нь Шаньси мужийн Пин—ян хотод, Шүнь нь Чүнь гэдэг газарт, Юй нь Хэнань мужийн Юй сумангийн Яньчжай хотод тус тус төвлөж байжээ.

Юйгийн үед Хятадад худаг гаргах аргыг олж, гол усгүй газарт хүмүүс оршин амьдрах бололцоотой болсон байна. Хамгийн гол нь Шар мөрөн зэрэг ихээхэн үерлэдэг голуудын усны аюулаас хамгаалах далан бариж, суваг шуудуу татах зэргээр газар усны ажлыг өргөн зохиож, усан намаг болдог газруудыг хатааж тариа тарих болж байжээ.

Яо, Шүнь, Юй нарын үе бол Хятадад овог, аймгийн хүн нэгдлийн байгуулал улам улмаар задарч, аажимдаа ангит нийгэм үүсэх үндэс суурь тавигдаж байсан цаг юм.

## НЕКОТОРЫЕ ВОПРОСЫ ДРЕВНЕЙШЕЙ ИСТОРИИ КИТАЯ

### (Резюме)

В статье дается общий краткий обзор истории первобытного Китая, охватывающей период заселения страны древнейшими людьми до конца III тысячелетия до н. э.

Как отмечает автор, вопреки утверждениям буржуазной историографии и теоретическим концепциям маоизма, все основные источни-

<sup>10</sup> Хятадын нэвтэрхий түүхийн тойм, дээд дэвтэр Бээжин. 1849, 16-р тал

ки и исследования подтверждают марксистско-ленинское освещение всей истории Китая вообще и рассматриваемого периода в частности.

Со времени первоначального заселения Китая первобытными людьми, страна постепенно развивалась, переходя от одной стадии социально-экономического развития к другим: от палеолита к неолиту, от последнего к бронзовому веку и т. д.

Колыбелью этногенеза китайцев является, согласно утверждениям самих китайских ученых и зарубежных авторов, регион среднего течения реки Хуанхэ, откуда они расселялись в другие части страны.

Общество Китая развивалось по общим закономерностям развития общества, хотя китайский этнос имел свои особенности в языке, быте, культуре и т. д.

Археологические находки в Маньчжурии, Внутренней Монголии, Синьцзяна, Тибета и других национальных районов говорят о том, что развитие в этих районах шло своим путем и имело свои особенности. В те далекие времена не только Китай влиял на ближних соседей, но и другие страны, даже удаленные, оказывали свое влияние на него.

В начале бронзы при полуполюгендарном предводителе Хуанди китайцы научились шелководству и развили различные ремесла, что явилось важным достижением этого народа и вкладом в мировую культуру.

На следующих этапах бронзового века в Китае успешно развивается земледелие и оседлая культура, что приводит к постепенному социально-имущественному расслоению общества, возникновению племенных союзов и военной демократии, непосредственно предшествующих появлению классового общества и государственности.

Прославленные Яо, Шунь и Юй являлись последними крупными предводителями этих племенных союзов, при которых уже воздвигались крепостные стены вокруг городов— цитаделей грядущих поколений рабовладельцев и центров раннекитайской цивилизации.